

Хувьцаа эргүүлэн худалдаж авах тухай

Компанийн тухай хуулийн 49 дүгээр зүйл, 76 дугаар зүйлийн 76.1.7, Компанийн дүрмийн 6 дугаар зүйлийн 6.14.2, Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2024 оны 6 дугаар сарын 27-ны өдрийн санал хураалтын шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Хувьцаа эзэмшигч Эйч Ви Эл Эл ХХК-иас 3,222,566 /гурван сая хоёр зуун хорин хоёр мянга таван зуун жаран зургаа/ ширхэг, нэг бүрийг 104.84 /нэг зуун дөрөв төгрөг наян дөрвөн мөнгө/ төгрөгөөр тооцон нийт 337,853,819.44 /гурван зуун гучин долоон сая найман зуун тавин гурван мянга найман зуун арван есөн төгрөг дөчин дөрвөн мөнгө/ төгрөгөөр хувьцаа эргүүлэн худалдан авахыг зөвшөөрсүгэй.
2. Компанийн хувьцааг эргүүлэн худалдан авах гэрээ, хэлцэл болон холбогдох бусад баримт бичигт компанийг төлөөлж гарын үсэг зурах, хувьцааг хууль тогтоомжийн дагуу шилжүүлэн авах, халаасны хувьцаагаар бүртгэх, холбогдох төлбөр тооцоог хийх ажлыг тогтоол батлагдснаас хойш 10 хоногийн дотор зохион байгуулж, хэрэгжилтийг хангуулж ажиллахыг Гүйцэтгэх захирал /Г.Сүхбаатар/-т даалгасугай.
3. Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан Санхүүгийн Зохицуулах хороо, Монголын Хөрөнгийн бирж, Үнэт Цаасны төвлөрсөн хадгаламжийн төв зэрэг холбогдох эрх бүхий байгууллагуудад мэдэгдэл хүргүүлж, нийтэд мэдээлэн ажиллахыг Төлөөлөн Удирдах Зөвлөлийн нарийн бичгийн дарга /Г.Есү-Үжин/-д даалгасугай.
4. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дэргэдэх Аудитын хороо /В.Ганзориг/-т үүрэг болгосугай.

ДАРГА



Ч.ГАНЗОРИГ